


Мөнгөний тойм

2012 оны 4 дүгээр сар

Инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс¹ 2012 оны 4 дүгээр сарын эцэст өмнөх сарынхаас 0.5 хувь, оны эхнээс 8.2 хувь, өмнөх оны мөн үеэс 16.0 хувь, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс өмнөх сарынхаас 0.2 хувь, оны эхнээс 8.4 хувь, өмнөх оны мөн үеэс 17.8 хувиар тус тус өслөө. Суурь инфляци² сарын 0.1 хувь, оны эхнээс 2.7 хувь, жилийн 10.9 хувь байв.




Тайлант сард мах, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн бараа бүтээгдэхүүний үнэ 1.5-2.1 хувиар өсч, харин бензин, дизелийн үнэ 4.5-6.5 хувиар буурчээ.

Хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлтийг бүлгээр нь авч үзвэл хүнсний барааны үнэ 31.0 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 20.1 хувь,

тээврийн бүлгийнх 14.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийнх 13.6 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр өсөлттэй бүлгүүд байлаа.


Сүүлийн 2 сарын турш жилийн инфляцийн 50 орчим хувийг хүнсний

бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт бүрдүүлсэн байна.



Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт³ өмнөх сараас 4.2 хувь, өмнөх оны мөн үеэс 18.9 хувиар өсч 6362.9 тэрбум төгрөгт хүрэв. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2011 оны 7 дугаар сараас хойш буурсаар байгаа бөгөөд жилийн өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 50.2 нэгж хувиар саарсан байна.



Тайлант сард валютын харилцахын жилийн өсөлтийн хурд өмнөх сарынхаас 36.0 нэгж хувь, банкнаас гадуурх мөнгөнийх 10.8 нэгж хувь, төгрөгийн харилцахынх 3.9 нэгж хувь, төгрөгийн

¹ Үндэсний Статистикийн Хорооны мэдээ.

² Мах, сүү, хүнсний ногоог хэрэглээний сагснаас хасч тооцов.

³ M2-мөнгөний нийлүүлэлт нь Бараг мөнгө, M1 мөнгөний нийлбэр.

хадгаламжийнх 1.3 нэгж хувиар тус тус буурч, харин валютын хадгаламжийнх 19.7 нэгж хувиар өсчээ.

2012 оны 4 дүгээр сарын мөнгөний үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг үлдэгдлээр нь авч үзвэл валютын хадгаламж өмнөх сараас 233.9 тэрбум төгрөг, төгрөгийн харилцах 56.9 тэрбум төгрөг, банкнаас гадуурх мөнгө 50.7 тэрбум төгрөгөөр тус тус өсч, харин валютын харилцах 84.2 тэрбум төгрөгөөр буурчээ. Төгрөгийн хадгаламж тайлант сард өөрчлөлт багатай байв.



M2 мөнгөний жилийн өсөлтийн 61.1 хувийг төгрөгийн хадгаламж, 23.0 хувийг төгрөгийн харилцах, 13.8 хувийг гадаад валютын хадгаламж, 2.4 хувийг банкнаас гадуурх мөнгө, -0.3 хувийг гадаад валютын харилцах тус тус бүрдүүлжээ.



Хадгаламж

Нийт хадгаламж өмнөх сарынхаас 6.3 хувь буюу 234.7 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеийнхээс 23.5 хувь буюу 758.2 тэрбум төгрөгөөр өсч 3981.0 тэрбум төгрөгт хүрэв.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж өмнөх сарынхаас 3.5 хувь буюу 8.9 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 9.9 хувь буюу 26.6 тэрбум төгрөгөөр буурч 242.6 тэрбум төгрөг болсон бол иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх сарынхаас 0.4 хувь буюу 9.6 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 30.8 хувь буюу 644.7 тэрбум төгрөгөөр өсч 2738.8 тэрбум төгрөгт хүрчээ. Гадаад валютын хадгаламж өмнөх сарынхаас 30.6 хувь буюу 233.9 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 16.3 хувь буюу 140.1 тэрбум төгрөгөөр өсч 999.6 тэрбум төгрөг болжээ.


Нийт хадгаламжийн 74.9 хувь нь төгрөгийн, 25.1 хувь нь валютын хадгаламж байсан бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжинд эзлэх хувь өмнөх сарынхаас 4.7 нэгж хувиар буурсан байна.



Гадаад, дотоод цэвэр актив

Гадаад цэвэр актив өмнөх сарынхаас 2.6 хувь, өмнөх оны мөн үеэс 17.7 хувиар өсч 3438.0 тэрбум төгрөг, дотоод цэвэр актив

өмнөх сарынхаас 6.2 хувь, өмнөх оны мөн үеэс 20.4 хувиар өсч 2924.9 тэрбум төгрөг болов.



Гадаад цэвэр активын дийлэнх хувийг эзэлдэг гадаад валютын цэвэр албан нөөц 2012 оны 4 дүгээр сард өмнөх сараас 0.1 хувь буюу 2.4 сая ам.доллар, өмнөх оны мөн үеэс 24.1 хувь буюу 512.2 сая ам.доллараар нэмэгдэж 2635.7 сая ам.доллар болов.

Нийт мөнгөний 54.0 хувь нь гадаад цэвэр активт, 46.0 хувь нь дотоод цэвэр активт байршиж байна.



Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх сарынхаас 6.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 46.4 хувиар өсч 1703.9 тэрбум төгрөгт хүрэв. Тайлант сард Төв банкинд дахь харилцах, хадгаламж өмнөх сараас 14.6 хувь буюу 171.1 тэрбум төгрөгөөр буурч, харин

банкнаас гадуурх мөнгө 11.3 хувь буюу 50.7 тэрбум төгрөг, банкуудын касс 4.9 хувь буюу 9.7 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.



Банкуудын Төв банкинд дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 12.4 нэгж хувиар нэмэгдэж 58.5 хувь болсон бол банкуудын кассын эзлэх хувь 0.9 нэгж хувиар буурч 12.2 хувь, банкнаас гадуурх мөнгөнийх 11.5 нэгж хувиар буурч 29.3 хувь болсон байна.

Зээл

Хадгаламжийн байгууллагуудаас⁴ олгосон зээл өмнөх сарынхаас 2.7 хувь буюу 154.5 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 49.4 хувь буюу 1962.1 тэрбум төгрөгөөр өсч 5936.0 тэрбум төгрөгт хүрчээ. Хадгаламжийн байгууллагуудаас хувийн хэвшилд олгосон нийт зээл өмнөх сарынхаас 3.1 хувь буюу 98.5 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 47.7 хувь буюу 1069.4 тэрбум төгрөгөөр өсч 3309.9 тэрбум төгрөгт, иргэдэд олгосон зээл өмнөх сарынхаас 2.1 хувь буюу 53.5 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс

⁴ Хадгаламжийн байгууллагад банкуудаас гадна мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд ордог харилцах, хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллага (Хадгаламж, зээлийн хоршоо) хамрагдана.

52.5 хувь буюу 896.8 тэрбум төгрөгөөр өсч 2606.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. Хувийн хэвшил болон иргэдэд олгосон зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд сүүлийн 3 сарын турш буурчээ.



Нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 55.8 хувь нь хувийн хэвшил, 43.9 хувь нь иргэд, 0.2 хувь нь улсын байгууллага, 0.1 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 93.5 хувийг хэвийн зээл, 1.2 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 5.3 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеийнхээс 4.3 нэгж хувиар буурчээ.



Банк бус санхүүгийн байгууллагуудын⁵ нийт зээлийн өрийн үлдэгдэл нь 2011 оны

⁵ Санхүүгийн байгууллагад банк болон бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллагаас гадна банк бус санхүүгийн байгууллага орно.


4 дүгээр улирлын байдлаар 119.0 тэрбум төгрөг байв. Нийт санхүүгийн байгууллагуудаас эдийн засагт оруулсан санхүүжилт нь 6055.0 тэрбум төгрөг байна.

Хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2012 оны 4 дүгээр сард өнгөрсөн оны мөн үеэс 3.9 нэгж хувиар өсч жилийн 14.88 хувь болов. Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү⁶ өмнөх сарынхаас 0.6 нэгж хувь, өнгөрсөн оны мөн үеэс 2.1 нэгж хувиар өсч жилийн 18.4 хувь болсон бол гадаад валютынх өмнөх сараас өөрчлөгдөөгүй, өнгөрсөн оны мөн үеэс 0.5 нэгж хувиар буурч жилийн 12.4 хувь болжээ. Харилцах, хадгаламжийн жигнэсэн дундаж хүү сүүлийн саруудад тогтвортой, өөрчлөлт багатай байна. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү жилийн 11.0, валютын хадгаламжийнх 5.6 хувь байв. Төгрөгийн харилцахын жигнэсэн дундаж жилийн хүү 2.8 хувь, валютынх 1.4 хувь байлаа.

Мөнгөний зах

2012 оны 4 дүгээр сард банк хоорондын захын арилжаагаар нийт 262.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 12.91 хувь байна.



⁶ Зарласан хүү.

2012 оны 4 дүгээр сарын 4-ний өдрөөс 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн хугацаанд банкууд дунджаар төгрөгийн заавал байлгах нөөцөд 523.5 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд 225.9 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 532.5 тэрбум төгрөг, валютын нөөцөд 353.2 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

Валютын ханш

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 2012 оны 4 дүгээр сарын эцэст 1316.11 төгрөг болж, өмнөх сараас 3 төгрөгөөр чангарч, өмнөх оны мөн үеэс 58 төгрөгөөр суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам. доллартай харьцах дундаж ханш 1313.13 төгрөг байв.